

# УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК

2025 оны 01 дугаар  
сарын 20-ны өдөр

№: 25/01

Улаанбаатар  
хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг  
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалт, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2025 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 10:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар тогтоосугай.
  - 1.1. Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
  - 1.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр, 2025 оны 02 дугаар сарын 09-ний өдрүүдэд өдөр тутмын сонин хэвлэл болон телевиз, радио зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэхээр тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үнд:
  - 2.1. Улсын их дэлгүүрийн барилгыг "Номин реалтор" ХХК-д түрээслүүлэх тухай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг хэлэлцүүлж, батлуулах.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд цахим хэлбэрээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс урьдчилан саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 17:00 цагаар тасалбар болгож, брокер дилирийн компани болон Нийслэлийн Хан-Уул дүүргийн 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө гудамж, 67/1 тоот хаягт байрлах "Номин юнайтед" цогцолборын 4-р давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Я.Навааныг томилсугай.
6. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал Х.Эрдэнэбаатар, гишүүдээр ТҮЗ-ийн нарийн бичгийн дарга М.Өлзийбат, Ахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилсугай.
  - 6.1. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

- 6.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалыг брокер дилерийн компаниудад 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн дотор цахим шуудангаар, эсхүл цаасан хэлбэрээр дамжуулан тараахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын даргаар Эдийн засагч Г.Өсөхбаярыг, тооллогын комиссын гишүүдээр Хуульч Ч.Нарангэрэл, Нягтлан бодогч Н.Сүрэнжав нарыг томилсугай.
- 7.1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх, хурлын ирц болон шийдвэрийг баталгаажуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэхийг Тооллогын комиссын дарга, гишүүдэд даалгасугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулж, ажлын 5 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга М.Өлзийбатад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Я.НАВААН